ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ЗАА-2025/014/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2025 он


Дарга,
тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас:99993365 Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар
Утас: 99105506 Цахим хаяг: BoldbaatarH@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Заяа
Утас: 90088028 Цахим хаяг: zayag@audit.gov.mn

Гэрээт аудитор : Ц.Алтантуул

Утас: 91195554 Цахим хаяг: tuul9565@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**


1. Хараат бус аудиторын дүгнэлт 3

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 7

3. Санхүүгийн тайлангийн тодруулга.......8

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 8

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 10

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт 11

4. Аудитын тайлан.......13

4.1 Ерөнхий зүйл .......13

4.2 Материаллаг байдал .......14

4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.......14

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .......14

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .......15

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .......16

5. Аудитын илрүүлэлт .......16

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл
**16**


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.02.18 № 148

танай________________-ны №________________-т

САНХҮҮ ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ГАНЧУЛУУН-Д

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус байгууллага нь урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлогоор 442.6 сая төгрөгийг бүрдүүлэн, үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан тодруулгуудад дүгнэлт өгөх аудитаар алдаа зөрчил илрээгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны тайлант оны төсөв нь өмнөх оны төсвөөс 46.9 хувиар өссөн. Энэ нь тэтгэвэрт гарах ажилтанд олгох нэг удаагийн тэтгэмжийн зардал 36.9 сая төгрөгөөр, 5 жил ажилласан албан хаагч нарт олгох тэтгэмжийн зардал 44.0 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31* *Iтөгрөгөөр/*

| Д/Д | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 7,589,169.00 | 7,283,547.00 |
| 2 | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | (0.00) | (0.00) |
| 8 | Банканд байгаа бэлэн мөнгө | (0.00) | (0.00) |
| 9 | Төгрөг | (0.00) | (0.00) |
| 10 | Төрийн сангийн харилцах | (0.00) | (0.00) |
| 60 | БАРАА МАТЕРИАЛ | 7,589,169.00 | 7,283,547.00 |
| 66 | Хангамжийн материал | 7,589,169.00 | 7,283,547.00 |
| 67 | Бичиг хэргийн материал | 1,144,380.00 | 1,575,820.00 |
| 68 | Аж ахуйн материал | 758,500.00 | 772,500.00 |
| 70 | Түлш шатах тослох материал | 3,220,289.00 | 2,689,227.00 |
| 73 | Бусад хангамжийн материал | 2,466,000.00 | 2,246,000.00 |
| 86 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 14,257,041.30 | 11,665,775.48 |
| 106 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 14,257,041.30 | 11,665,775.48 |
| 108 | Биет хөрөнгө | 14,257,041.30 | 11,665,775.48 |
| 111 | Авто тээврийн хэрэгсэл | 4,846,888.95 | - |
| 112 | Хуримтлагдсан элэгдэл | (4,846,888.95) | - |
| 113 | Машин, тоног төхөөрөмж | 22,346,405.00 | 22,851,755.00 |
| 114 | Хуримтлагдсан элэгдэл | (11,031,895.32) | (14,148,776.18) |
| 115 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 11,075,075.00 | 11,870,075.00 |
| 116 | Хуримтлагдсан элэгдэл | (8,132,543.38) | (8,907,278.34) |
| 127 | Программ хангамж | 880,000.00 | 880,000.00 |
| 128 | Хасагдуулаг | (880,000.00) | (880,000.00) |
| 137 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 21,846,210.30 | 18,949,322.48 |
| 138 | НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | 1,735,204.51 | 756,000.00 |
| 139 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 1,735,204.51 | 756,000.00 |
| 164 | Өглөг | 1,735,204.51 | 756,000.00 |
| 165 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | 1,735,204.51 | (0.00) |
| 170 | Бусад өглөг | - | 756,000.00 |
| 171 | Байгууллагад төлөх өглөг | - | 756,000.00 |
| 214 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 20,111,005.79 | 18,193,322.48 |
| 215 | Засгийн газрын хувь оролцоо | 20,111,005.79 | 18,193,322.48 |
| 223 | Хуримтлагдсан үр дүн | 20,111,005.79 | 18,193,322.48 |
| 224 | Өмнөх үеийн үр дүн | 20,111,005.79 | 20,111,005.79 |
| 225 | Тайлант үеийн үр дүн | - | (1,917,683.31) |
| 231 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 21,846,210.30 | 18,949,322.48 |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31* *\/төгрөгөөр/*

| Д/д | ҮЗҮҮЛЭЛТ | ӨМНӨХ ОН | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 266,388,400.00 | 442,638,600.00 |
| 76 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 897,000.00 | - |
| 77 | Нийтлэг татварын бус орлого | 897,000.00 | - |
| 92 | Бусад орлого | 897,000.00 | - |
| 111 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 265,491,400.00 | 442,638,600.00 |
| 129 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 265,491,400.00 | 442,638,600.00 |
| 130 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 265,491,400.00 | 442,638,600.00 |
| 147 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 264,505,481.63 | 444,556,283.31 |
| 148 | УРСГАЛ ЗАРДАЛ | 264,505,481.63 | 444,556,283.31 |
| 149 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 260,102,315.47 | 359,768,944.59 |
| 150 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 201,843,759.01 | 292,417,687.77 |
| 151 | Цалин | 103,253,258.06 | 140,003,123.28 |
| 152 | Нэмэгдэл цалин | 71,146,337.40 | 119,448,236.99 |
| 153 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,667,576.00 | 13,985,518.08 |
| 154 | Урамшуулал | 20,776,587.55 | 18,980,809.42 |
| 157 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 29,383,939.34 | 37,032,400.00 |
| 158 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 20,231,939.21 | 25,182,000.00 |
| 159 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 2,307,156.54 | 2,962,600.00 |
| 160 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 1,845,685.23 | 2,370,100.00 |
| 161 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 454,523.49 | 592,500.00 |
| 162 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 4,544,634.88 | 5,925,200.00 |
| 170 | Хангамж, бараа материалын зардал | 7,151,956.00 | 9,401,341.00 |
| 171 | Бичиг хэргийн материал | 2,005,120.00 | 1,745,460.00 |
| 172 | Тээвэр, шатахууны зардал | 3,973,436.00 | 4,870,862.00 |
| 173 | Шуудан холбоо интернэтийн төлбөр | 955,600.00 | 1,920,519.00 |
| 176 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 217,800.00 | 864,500.00 |
| 185 | Эд хогшил, урсгал засварын зардал | 256,600.00 | 340,000.00 |
| 186 | Багаж хэрэгсэл | 256,600.00 | - |
| 189 | Урсгал засвар | - | 340,000.00 |
| 190 | Томилолт, зочны зардал | 15,999,600.00 | 12,969,900.00 |
| 192 | Дотоод томилолтын зардал | 15,999,600.00 | 12,969,900.00 |
| 194 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 909,000.00 | 2,496,000.00 |
| 196 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | - | 1,296,000.00 |
| 198 | Тээврийн хэрэгслийн татвар | 46,000.00 | - |
| 200 | Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | 863,000.00 | 1,200,000.00 |
| 209 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,557,461.12 | 5,111,615.82 |
| 210 | Бараа үйлчилгээний бусад зардал | 815,000.00 | 720,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 211 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 500,000.00 | 500,000.00 |
| 212 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 3,242,461.12 | 3,891,615.82 |
| 224 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4,403,166.16 | 84,787,338.72 |
| 228 | Бусад урсгал шилжүүлэг | 1,897,000.00 | 82,275,904.00 |
| 234 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 36,914,800.00 |
| 235 | Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 41,632,104.00 |
| 236 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 1,897,000.00 | 3,729,000.00 |
| 242 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 2,506,166.16 | 2,511,434.72 |
| 245 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,506,166.16 | 2,511,434.72 |
| 268 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | 1,882,918.37 | (1,917,683.31) |
| 288 | НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI) | 1,882,918.37 | (1,917,683.31) |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31* *\/төгрөгөөр/*

| SORT_ID | ITEM_NAME | ГҮЙЦЭТГЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 266,388,400.00 | 442,638,600.00 |
| 77 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 897,000.00 | - |
| 78 | Нийтлэг татварын бус орлого | 897,000.00 | - |
| 92 | Бусад орлого | 897,000.00 | - |
| 110 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 265,491,400.00 | 442,638,600.00 |
| 129 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 265,491,400.00 | 442,638,600.00 |
| 130 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 265,491,400.00 | 442,638,600.00 |
| 147 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 262,481,000.00 | 441,338,250.00 |
| 148 | УРСГАЛ ЗАРДАЛ | 262,481,000.00 | 441,338,250.00 |
| 149 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 258,077,833.84 | 356,550,911.28 |
| 150 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 203,120,993.84 | 294,152,892.28 |
| 151 | Үндсэн цалин | 104,530,492.89 | 141,738,327.79 |
| 152 | Нэмэгдэл | 71,146,337.40 | 119,448,236.99 |
| 153 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,667,576.00 | 13,985,518.08 |
| 154 | Үр дүнгийн урамшуулал | 20,776,587.55 | 18,980,809.42 |
| 157 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 26,371,500.00 | 37,032,400.00 |
| 158 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 17,932,500.00 | 25,182,000.00 |
| 159 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 2,109,800.00 | 2,962,600.00 |
| 160 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 1,687,800.00 | 2,370,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 161 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 422,000.00 | 592,500.00 |
| 162 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 4,219,400.00 | 5,925,200.00 |
| 170 | Хангамж, бараа материалын зардал | 9,399,340.00 | 9,095,719.00 |
| 171 | Бичиг хэрэг | 1,837,950.00 | 2,176,900.00 |
| 172 | Тээвэр, шатахуун | 5,956,000.00 | 4,339,800.00 |
| 173 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,164,190.00 | 1,920,519.00 |
| 176 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 441,200.00 | 658,500.00 |
| 185 | Эд хогшил, урсгал засварын зардал | 180,400.00 | 340,000.00 |
| 186 | Багаж техник хэрэгсэл | 180,400.00 | - |
| 189 | Урсгал засвар | - | 340,000.00 |
| 190 | Томилолт, зочны зардал | 15,999,600.00 | 12,969,900.00 |
| 192 | Дотоод албан томилолт | 15,999,600.00 | 12,969,900.00 |
| 194 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,246,000.00 | 1,740,000.00 |
| 196 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 540,000.00 |
| 198 | Тээврийн хэрэгслийн татвар | 46,000.00 | - |
| 200 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,200,000.00 | 1,200,000.00 |
| 208 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,760,000.00 | 1,220,000.00 |
| 209 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,260,000.00 | 720,000.00 |
| 210 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 500,000.00 | 500,000.00 |
| 221 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 4,403,166.16 | 84,787,338.72 |
| 225 | Бусад урсгал шилжүүлэг | 1,897,000.00 | 82,275,904.00 |
| 231 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 36,914,800.00 |
| 232 | Хөдөө орон нутагт тогтвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 41,632,104.00 |
| 233 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 1,897,000.00 | 3,729,000.00 |
| 239 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 2,506,166.16 | 2,511,434.72 |
| 242 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,506,166.16 | 2,511,434.72 |
| 250 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 3,907,400.00 | 1,300,350.00 |
| 251 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 261 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 3,907,400.00 | 1,300,350.00 |
| 262 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 3,907,400.00 | 1,300,350.00 |
| 263 | Дотоод эх үүсвэрээр | 3,907,400.00 | 1,300,350.00 |
| 275 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 3,907,400.00 | 1,300,350.00 |
| 278 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (3,907,400.00) | (1,300,350.00) |

| | | | |
|---|---|---|---|
| 279 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 303 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | (0.00) | - |
| 304 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | (0.00) |
| 305 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | (0.00) |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31* *Iтөгрөгөөр/*

| | ҮЗҮҮЛЭЛТ | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|
| 0 | ДАНС | 51210+51220 | |
| 9 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 20,111,005.7 | 20,111,005.7 |
| 10 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 20,111,005.7 | 20,111,005.7 |
| 12 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 20,111,005.7 | 20,111,005.7 |
| 17 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | -1,917,683.3 | -1,917,683.3 |
| 18 | 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 18,193,322.4 | 18,193,322.4 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*2024 оны 12 дугаар сарын 31* *Iтөгрөгөөр/*

| SORT_ID | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | (0.00) |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 442,638,600.00 | 439,257,165.28 |
| 3 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 442,638,600.00 | 439,257,165.28 |
| 4 | Бараа, үйлчилгээний зардал | 359,677,800.00 | 356,981,261.28 |
| 5 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 296,259,300.00 | 294,152,892.28 |
| 6 | Үндсэн цалин | 143,130,000.00 | 141,738,327.79 |
| 7 | Нэмэгдэл | 124,445,300.00 | 119,448,236.99 |
| 8 | Унаа, болон бусад нөхөн олговор | 9,600,000.00 | 13,985,518.08 |
| 9 | Урамшуулал | 19,084,000.00 | 18,980,809.42 |
| 11 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 37,032,400.00 | 37,032,400.00 |
| 12 | Тэтгэврийн даатгал | 25,182,000.00 | 25,182,000.00 |
| 13 | Тэтгэмжийн даатгал | 2,962,600.00 | 2,962,600.00 |
| 14 | ҮОМШӨ ний даатгал | 2,370,100.00 | 2,370,100.00 |
| 15 | Ажилгүйдлийн даатгал | 592,500.00 | 592,500.00 |
| 16 | Эрүүл мэндийн даатгал | 5,925,200.00 | 5,925,200.00 |
| 22 | Хангамж, бараа материалын зардал | 9,695,800.00 | 8,945,719.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 23 | Бичиг хэрэг | 1,000,000.00 | 2,176,900.00 |
| 24 | Тээвэр (шатахуун) | 5,000,000.00 | 4,339,800.00 |
| 25 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 3,000,000.00 | 1,770,519.00 |
| 28 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 695,800.00 | 658,500.00 |
| 34 | Эд хогшил худалдан авах | 3,326,700.00 | 1,640,350.00 |
| 35 | Багаж, техник, хэрэгсэл | 2,500,000.00 | 1,300,350.00 |
| 38 | Урсгал засвар | 826,700.00 | 340,000.00 |
| 39 | Томилолт, зочны зардал | 10,000,000.00 | 12,969,900.00 |
| 41 | Дотоод албан томилолт | 10,000,000.00 | 12,969,900.00 |
| 43 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 2,143,600.00 | 1,740,000.00 |
| 45 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 540,000.00 | 540,000.00 |
| 46 | Даатгалын үйлчилгээ | 250,000.00 | - |
| 47 | Тээврийн хэрэгслийн татвар | 53,600.00 | - |
| 48 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 100,000.00 | - |
| 49 | Мэдээллийн технологийн зардал | 1,200,000.00 | 1,200,000.00 |
| 53 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,220,000.00 | 500,000.00 |
| 54 | Бараа үйлчилгээний бусад зардал | 720,000.00 | - |
| 55 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 500,000.00 | 500,000.00 |
| 66 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 82,960,800.00 | 82,275,904.00 |
| 70 | Бусад урсгал шилжүүлэг | 82,960,800.00 | 82,275,904.00 |
| 76 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 36,914,800.00 | 36,914,800.00 |
| 77 | Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж | 44,046,000.00 | 41,632,104.00 |
| 78 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 2,000,000.00 | 3,729,000.00 |
| 97 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | 442,638,600.00 |
| 98 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | - | 36,914,800.00 |
| 99 | Улсын төсвөөс санхүүжих | - | 36,914,800.00 |
| 103 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | - | 405,723,800.00 |
| 104 | Орон нутгийн төсвөөс | - | 405,723,800.00 |
| 127 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | (0.00) |
| 128 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | (0.00) |
| 129 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - |
| 130 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - |
| 133 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 10.00 | 10.00 |
| 134 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 135 | Гүйцэтгэх ажилтан | 9.00 | 9.00 |
| 138 | СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/ | - | - |
| 148 | ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО | - | - |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

*Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны үйл ажиллагааны чиглэл:*

- Санхүүгийн хяналт шалгалт хийх, зөвлөн туслах

*Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны зорилго:* Дотоод аудитын олон улсын стандартад нийцсэн үйл ажиллагаа явуулж, төсөв захирагчдыг үүргээ хэрэгжүүлэхэд нь салбарын бодит мэдээллээр хангаж, оновчтой шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлж, байгууллагын үнэ, цэнийг нэмэгдүүлэх, эрсдэлийн удирдлагаар хангахад оршино.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 44 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 94 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

*Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны үйл ажиллагаанд мөрддөг хууль:*

1. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
2. Төрийн албаны тухай хууль
3. Төсвийн тухай хууль
4. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
5. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
6. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
7. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
8. Хөдөлмөрийн тухай хууль
9. Төрийн хяналт шалгалтын тухай хууль холбогдох хууль тогтоомж

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн мэргэжилтнүүд хяналтыг хэрэгжүүлж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан " Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 2,896.9 мянган төгрөгөөр буюу 13.2 хувиар буурсан байна.

***Хүснэгт 1.*** *Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Бараа материал | 7,589.1 | 7,283.5 | -305.6 |
| Үндсэн хөрөнгө | 14,257.0 | 11,665.7 | -2591.3 |
| **Нийт хөрөнгө** | **21,846.2** | **18,949.3** | **-2,896.9** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 21,846.2 | 18,949.3 | -2,896.9 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **21,846.2** | **18,949.3** | **-2,896.9** |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайланд онд:**

Бараа материалын эхний үлдэгдэл 7,589.1 мянган төгрөг байсан бөгөөд төсвийн хөрөнгөөр 5,399.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 5,704.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, эцсийн үлдэгдэл 7,283.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 305.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 1,300.3 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 4,846.8 мянган төгрөгийн хөрөнгийг шийдвэрийн дагуу акталж, жилийн эцэст 11,665.7 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 3,891.6 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 442,638.6 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 442,638.6 мянган төгрөгийг улсын төсвөөс төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 439,442.3 мянган төгрөг буюу 99.2 хувьтай байна. Энэ нь цалин, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | | | | | |
| **70106** | **Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага** | | | | |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 359,677.8 | 357,166.4 | 2,511.4 | 99,3% |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 82,960.8 | 82,275.9 | 684.9 | 99,1% |
| **НИЙТ** | | **442,638.6** | **439,442.3** | **3,196.3** | **99.2%** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Тайлант онд нэмэлт санхүүжилт төвлөрүүлээгүй.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4.АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу аймгийн Санхүү хяналт дотоод аудитын албаны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүлд аудит ХХК-ийн гэрээт аудитор Ц.Алтантуул гүйцэтгэж хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Заяа , аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Санхүү хяналт дотоод аудитын албаны 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр 03 дугаартай албан тоотоор ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 444,556.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,668.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан.**

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн Санхүү хяналт дотоод аудитын албаны шилэн дансны мэдээллийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай *нийцсэн байна* гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Аймгийн Санхүү хяналт дотоод аудитын албаны 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх онд алдаа, зөрчил илрээгүй.

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 12,162.0 мянган төгрөгийн зардлыг аккрэуль сууриар бүртгээгүй алдаа илэрснийг залруулсан.

**5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй.**

**5.2 Албан шаардлага хүргүүлээгүй**

**5.3 Зөвлөмж өгөгдөөгүй**

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээл-лийг тусгахгүй орхигдуул-сан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруула агүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Аккруэль сууриар бүртгэл хөтлөөгүй | 1 | 12,162.0 | | | 1 | 12,162.0 | 1 | 12,162.0 | | | | |
| **Дүн** | 1 | 12,162.0 | | | 1 | 12,162.0 | 1 | 12,162.0 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | | | | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР Х.БОЛДБААТАР

АХЛАХ АУДИТОР Г.ЗАЯА

БОЛОВСРУУЛСАН

СҮЛД АУДИТ ХХК-ИЙН

ГЭРЭЭТ АУДИТОР Ц.АЛТАНТУУЛ

ОГНОО: 2025-02-22